

2017 ОНЫ 5 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу хүлээгдлийн мэдээ ирүүлэх 12 байгууллагаас 5 дугаар сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 8 байгууллага мэдээ ирүүлсэн.

Нэг. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн эмчийн үзлэгийн хүлээгдэл:

2017 оны 5 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ-ийн амбулаторийн үзлэг хүлээгдэлтэй ажилласан байна. Үүнд:

УНТЭ-ийн амбулаторийн 5 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэнээс нүдний кабинетэд 161, шүдний эмчилгээний кабинетэд 83 үйлчлүүлэгч тус бүр 6 хоногийн хүлээгдэлтэй, мэдрэлийн кабинетэд 3 хоногийн хүлээгдэлтэй 91 үйлчлүүлэгч, элэг цөсний кабинетэд 36, үе судлалын кабинетэд 80 үйлчлүүлэгч тус бүр 2 хоногийн хүлээгдэлтэй байна. Өмнөх сард тус эмнэлгийн 9 кабинетэд /үе судлал, нүдний даралт, шүдний эмчилгээ, мэдрэл, чих хамар хоолой, нүд, арьс харшил, урлоги, зүрх судас/ 2-7 хоногийн хүлээгдэл бүртгэгдэж байсан байна.

4 дүгээр сард УХТЭ-ийн амбулаторийн 8 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэн бол энэ сард 11 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: 4-6 хоногийн хүлээгдэл мэдрэлийн кабинетэд 43 үйлчлүүлэгч, 3 хоногийн хүлээгдэл бөөрний кабинетэд 5 үйлчлүүлэгч, 2 хоногийн хүлээгдэл уушги /6/, мэс засал /4/, нүдний кабинет /5/, хоол боловсруулах эрхтэн судлал /26/, эмэгтэйчүүдийн кабинетэд /9/, 1 хоногийн хүлээгдэл зүрх судас /12/, булчирхай /6/, урологи, чих хамар хоолойн кабинетэд тус бүр 1 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. УХТЭ-ийн хүлээгдлийг 4 дүгээр сарын байдалтай харьцуулахад бөөр судлал, зүрх судас, уушги, мэс засал, мэдрэл, нүд, хоол боловсруулах эрхтэн, эмэгтэйчүүд судлалын кабинетийн хүлээгдлийн хугацаа нэмэгдсэн байна.

УГТЭ-ийн амбулаторийн тасагт 4 дүгээр сард хүлээгдэл бүртгэгдээгүй, 5 дугаар сард 3 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэнээс зүрх судасны кабинетэд 85, булчирхай судлалын кабинетэд 12, хоол боловсруулах кабинетэд 19 үйлчлүүлэгч тус бүр 1 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.


ЭХЭМҮТ-ийн амбулаторийн 5 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэн. Зүрх судасны кабинетэд 258 үйлчлүүлэгч 3 хоног, мэдрэлийн кабинетэд 365 үйлчлүүлэгч 3 хоног, нүдний кабинетэд 357 үйлчлүүлэгч 4-6 хоногийн хүлээгдэлтэй, хоол боловсруулах эрхтэний эмгэг судлалын кабинетэд 24 үйлчлүүлэгч 1 хоногийн хүлээгдэлтэй байсан бол хараа хамгаалах кабинетэд 506 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж үйлчлүүлжээ.

Тус эмнэлэгт энэ сард цахим эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд e_health программыг шинэчлэн суулгаж байгаатай холбогдуулан анхан болон давтан үзлэгийг давхцуулан бүртгэсэн тул хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


ХСҮТ-ийн 12 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэнээс элэг цөс нойр булчирхайн мэс заслын кабинет 7-оос дээш хоногийн хүлээгдэлтэй 53 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн кабинетэд 7 хүртэл хоногийн хүлээгдэлтэй 64, хими эмчилгээнд /26/, толгой хүзүүний мэс заслын тасагт /38/, хавдрын /28/ кабинетэд тус бүр 4-6 хоног, зүрх судсанд /36/, цээжний хөндийн мэс заслын кабинетэд /38/ тус бүр 1-6 хоног, туяа эмчилгээнд 3 хоног /18/, хөнгөвчлөх эмчилгээнд 2 хоног /7/, мэс засал /3/, сэргээн засах /2/ эмчилгээний кабинет тус бүр 1 хоногийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сартай харьцуулахад ХСҮТ-ийн мэс заслын кабинетийн хүлээгдэл буурч, бусад кабинетүүдэд хүлээгдлийн хугацаа болон үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэн байна.

ГССҮТ-ийн гавал тархины гэмтлийн кабинетэд 4 үйлчлүүлэгч 1-2 хоног, гар сарвуу бичил мэс заслын кабинетэд 36 үйлчлүүлэгч 1-3 хоног, хүзүү, нуруу нугасны гэмтлийн кабинетэд 2 үйлчлүүлэгч 1 хоног, хүүхдийн гэмтлийн кабинетэд 4 үйлчлүүлэгч, яс үений гэмтлийн кабинетэд 3 үйлчлүүлэгч тус бүр 2 хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.


УХТЭ, УГТЭ-ийн 5 дугаар сарын амбулаторийн үзлэгийн зарим кабинетийн хүлээгдлийг /үйлчлүүлэгчийн тоогоор/ харьцуулсан нь:



УНТЭ-ийн 4 ба 5 дугаар сарын амбулаторийн кабинетүүдийн нийт хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



ХСҮТ-ийн 3,4,5 дугаар сарын амбулаторийн үзлэгийн нийт хүлээгдлийн тоог кабинетийн төрлөөр гаргавал:



Хоёр. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2017 оны 5 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны кабинетуудад тус тус хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн оношлогооны кабинетүүдээс хэвлийн Эхо 3-6 хоног /126 үйлчлүүлэгч/, ходоодны дуран 2 хоног /12/, холтер 2 хоног /12/, радиоимунологи 7-14 хоног /179/, бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээ 7-14 хоног /41/, зүрхний Эхо 2 хоног /30/, ачаалалтай зүрхний сорил 3-6 хоногийн /8/ хүлээгдэлтэй байна.


УХТЭ-т хэвлийн Эхо /31 үйлчлүүлэгч/, рентген зураг /15/, ЭКГ /9/, доплерографийн шинжилгээ /16/ хийлгэхэд 1-2 хоног, ходоодны дуран /8/, тархины цахилгаан бичлэг /1/, нүдний уг дурандуулахад /4/ 1 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

УГТЭ-т рентген зураг авахуулахад 1-6 хоног /52 үйлчлүүлэгч/, хэвлийн Эхо 1-2 хоног /96/, тархины цахилгаан бичлэг 1-3 хоног /9/, доплерографийн шинжилгээ 6 хүртэл хоног /17/, зүрхний Эхо 1-2 хоног /8/ харин дурангийн шинжилгээ 1-15 хоногийн хүлээгдэлтэй /21/ байна.


ЭХЭМҮТ-ийн түнхний Эхо шинжилгээнд 2 хоногийн хүлээгдэлтэй 485 үйлчлүүлэгч, сонсголын бичлэг хийлгэхэд 3-6 хоногийн хүлээгдэлтэй 418 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын оношлогоонд 77 үйлчлүүлэгч бүртгэгдсэнээс 18 үйлчлүүлэгч өдөртөө шинжилгээ хийлгэж, 9 үйлчлүүлэгч 1 хоног, 7 үйлчлүүлэгч 2 хоногоор хүлээж үйлчлүүлсэн байна.

Төв эмнэлгүүдийн оношлогооны кабинетийн 5-р сарын хүлээгдлийг хугацаагаар /хоногоор/ харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний 3, 4, 5 дугаар сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/




Гурав. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2017 оны 5 дугаар сард УХТЭ, УГТЭ лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т цусны шинжилгээ 54, шээсний шинжилгээ 51, биохими 297, бактериологи 26, иммунологи шинжилгээнд 35 үйлчлүүлэгч тус бүр 2 хоног, серологи 7, цитологи, коагулограммын шинжилгээнд 9 үйлчлүүлэгч тус бүр 1 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т цусны шинжилгээ 99 үйлчлүүлэгч, шээсний ерөнхий шинжилгээ 63, биохимийн шинжилгээ 138, иммунологийн шинжилгээнд 46 үйлчлүүлэгч тус бүр 1-6 хүртэл хоног, коагулограммын шинжилгээнд 9 үйлчлүүлэгч 2 хоног, бактериологийн шинжилгээ өгөхөөр 21 үйлчлүүлэгч 1 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УНТЭ, УХТЭ-ийн лабораторийн кабинетийн 5-р сарын
хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2017 оны 5 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХСҮТ, СЭМҮТ, УАУТХ-д бүртгэгдсэн.

УНТЭ-ийн мэс заслын тасагт 4 үйлчлүүлэгч 6 хүртэл хоногоор, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 2 үйлчлүүлэгч, дотоод шүүрлийн тасагт 4 үйлчлүүлэгч тус бүр 14 хоног хүртэл хугацаагаар хэвтэн эмчлүүлэхээр хүлээж үйлчлүүлжээ. Өмнөх сард тус эмнэлэгт 27 үйлчлүүлэгч 1-3 хоногоор хэвтэн эмчлүүлэхээр хүлээснээс дотоод шүүрлийн тасагт 14, уламжлалт эмчилгээний тасагт 8, мэс засал 2, бөөр судлалын тасагт 3 үйлчлүүлэгч хүлээсэн байна.

УХТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл өмнөх сард 160 тохиолдол бүртгэгдэж байсан бол УГТЭ-т 97 тохиолдол 4-р сард бүртгэгдсэн байна.

5-р сард УХТЭ-т бөөр судлал, зүрх судас, мэс засал, мэдрэл, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр нийт 103 үйлчлүүлэгч 1-7 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн бол УГТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасгуудад нийт 222 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээж үйлчлүүлжээ.

УХТЭ, УГТЭ-ийн тусламж үйлчилгээний 5-р сарын хүлээгдлийг хүснэгтээр харуулбал:

Тасгийн нэр	Бөөр судлал		Зүрх судас		Уушги судлал		Хоол боловсруулах		Мэс засал		Мэдрэл		Уламжлалт		Мэдрэлийн мэс засал	
	УХТЭ	УГТЭ	УХТЭ	УГТЭ	УХТЭ	УГТЭ	УХТЭ	УГТЭ	УХТЭ	УГТЭ	УХТЭ	УГТЭ	УХТЭ	УГТЭ		
Ор хүлээж байгаа өвчтний тоо	6	6	5	30	6	23	21	53	31		27	20	7		90	
Үүнээс	1-3 хоног	1	4	1	10	6	6	7	38	15		10	6	7		9
	3-6 хоног	2	2	4	5		14	6	15	16		17	6			15
	7-14хоног	3			10		3	8					8			21
	15-30 хоног				5											25
	1 сараас дээш															20

ХСҮТ-ийн элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасагт 165 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэнээс 1-3 хоногоор 36 үйлчлүүлэгч, 3-6 хоногоор 40, 7-14 хоног 49, 15-30 хоног 31, 1 сараас дээш хугацаагаар 9 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байна.


4 дүгээр сард тус тасгийн хүлээгдэл 201 байсан бол 5-р сард 165 болж хүлээгдэл 36 тохиолдлоор буурсан байна.

Хөнгөвчлөх эмчилгээний тасагт 63 үйлчлүүлэгч, хими эмчилгээний тасагт 39 үйлчлүүлэгч тус бүр 1-30 хоногийн хүлээгдэлтэй байна. Өмнөх сартай харьцуулахад хөнгөвчлөх эмчилгээний тасгийн хүлээгдлийн тохиолдол 9, хими эмчилгээ 1 тохиолдлоор буурсан байна. Өдрийн хими эмчилгээний тасагт 134 үйлчлүүлэгч 1-30 хүртэл хоногоор хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна.


УАУТХ-д 4 дүгээр сард 205 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж байсан бол 5-р сард 109 болж 96 тохиолдлоор буурчээ. Тэдгээрийн 33,9% нь 1-3 хоног, 26,6% нь 3-6 хоног, 39,4% нь 7-14 хоногийн хугацаанд хүлээгдэлтэй байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасгийн хүлээгдэл 49 байгаа нь өмнөх сартай /84/ харьцуулахад 35 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Тус тасагт 1-3 хоногоор хэвтүүлэн эмчлэх 8, 3-6 хоногоор 9, 7-14 хоногоор 25, 15-30 хоногоор 7 үйлчлүүлэгч хүлээж байна.

4,5 дугаар сард ХСҮТ-ийн зарим тасагт хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн үйлчлүүлэгчдийн тоо



УАУТХ, СЭМҮТ-ийн 5 дугаар сарын хэвтүүлэн эмчлэх тусламжийн хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хамгийн олон хоногийн хүлээгдэл СХД-ийн ЭМТ-ийн мэдрэлийн тасагт 9 үйлчлүүлэгч 1 сараас дээш хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.


Дүүргийн эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний 5 дугаар сарын хүлээгдлийг 4 дүгээр сартай харьцуулан хүснэгтээр харуулбал:

№	Тасаг	Үзүүлэлт	СХД ЭМТ		ХУД ЭМТ		ЧД ЭМТ		НД ЭМТ		БН ЭМТ		БГД ЭМТ		БЗД НЭ		ХУД НЭ		
			4 сар	5 сар	4 сар	5 сар	4 сар	5 сар	4 сар	5 сар	4 сар	5 сар	4 сар	5 сар	4 сар	5 сар	4 сар	5 сар	
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа нийт өвчтний тоо	77	62	9	13	1		4	2	27	25	88	50			2		
		Үүнээс	1-3 хоног	7	10	2		1		4	2			2	3			2	
			3-6 хоног	16	9	7	10					5	12	12	8				
			7-14хоног	18	18	3						12	8	36	19				
			15-30 хоног	21	16							10	5	38	20				
			1 сараас дээш	15	9														
2	Дотор	Ор хүлээж байгаа нийт өвчтний тоо	139	103	72	69	5	3	63	28		8	87	90	21	17	10		
		Үүнээс	1-3 хоног	3		26	23	3	2	18	14		7	12	6	11	7	10	
			3-6 хоног	14	5	24	22	2	1	12	7		1	12	4	5	5		
			7-14хоног	20	6	16	22			20	7			15	17	4	3		
			15-30 хоног	102	92	6	2			10				48	63	1	2		
			1 сараас дээш							3									
3	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа нийт өвчтний тоо	65	68															
		Үүнээс	1-3 хоног	16	21														
			3-6 хоног	14	27														
			7-14хоног	35	20														
			15-30 хоног																
			1 сараас дээш																


Нийслэлийн түргэн тусламжийн төвд 5 дугаар сард 23285 дуудлага бүртгэгдсэний 35,6%-ийг 0-20 минутад, 31,2%-ийг 21-40 минутад, 18,3%-ийг 41-60 минутад, 14,9 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 5 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 1,3%-иар нэмэгдэж, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 0,7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2-оос 5 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдэл /дуудлагын тоогоор/



2017 оны эхний 5 сард нийслэлийн түргэн тусламжийн төвд ирсэн нийт дуудлага



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЧАНАР, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АЛБА

